



Ерөнхийлөгч  
Рассэлл М.Нэлсон

## Мормоны Номон дахь хүч

**Б**и Мормоны Номын тухай бодох үедээ хүч гэдэг үгийн талаар боддог. Мормоны Номон дахь үнэнд бидний бодгалиудыг эдгээх, тайвшруулах, хүчирхэгжүүлэх, урам зориг өгөх хүч бий.

Мормоны Ном бол . . .

- Есүс Христийн бас нэгэн гэрээ юм. Үүнийг бичсэн олон бошиглогч Есүс Христийг харсан. Мормоны Номон дээр Түүний тухай тэдний гэрчлэлүүд гардаг.
- Олон зуун жилийн өмнө эртний Америкт амьдарч байсан хүмүүст Түүний номлосон тохинууллын цэдэг.
- Үнэн шүү!

Би таныг Мормоны Номыг уншихад урьж байна. Би таныг уншиж байхдаа Аврагчийн талаар дурдаж буй шүлэг бүрийг тэмдэглэхэд урамшуулж байна. Бид үүгээр дамжуулан Түүнд илүү ойртож чадна. Өөрчлөлтүүд, бүр гайхамшиг ч тохиолдож эхлэх болно. ●

*"Мормоны Ном: Үүнгүйгээр таны амьдрал ямар байх байсан бэ?" гэсэн үгээс авав. 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган, "Израилыг цуглуулах ажил дахь эгч нарын оролцоо," 2018 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 141.*

## Мормоны Номоос Есүсийг олох нь

Ерөнхийлөгч Нэлсон биднийг Мормоны Номыг уншиж байхдаа Есүс Христийн нэрийг хайж олоход урьсан. Есүсийг сударт олон нэрээр нэрлэдэг. Таны хайж болох хэдэн нэр бол:

**Бурханы Хүү**  
(3 Нифай 5:13)

**Бурханы Хурга**  
(Алма 7:14)

**Мессиа**  
(2 Нифай 2:6)

**Аврагч**  
(Мозая 3:20)

**Их Эзэн**  
(Ифер 3:6)

**Христ**  
(2 Нифай 32:3)

**БҮТЭЭГЧ**  
(Алма 30:44)

